



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 21

Мандалговь

┐ Сонгуулийн ухуулах хуудас болон зурагт
самбар байрлуулах байршлыг тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3, 41.5, 41.6 дахь заалтуудыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. Сайнцагаан суманд сонгуулийн сурталчилгааны ухуулах хуудас болон зурагт самбарыг нийтийн эзэмшлийн гудамж талбай, олон нийтийн газарт байрлуулах байршлыг дор дурьдсанаар тогтоосугай.

Үүнд : 1. Г. Чагдаржавын гудамж

2. Ж. Наранцацралтын гудамж

3. С. Буяннэмэхийн өргөн чөлөө

4. Найрамдлын гудамж

5. Худалдааны гудамж

6. Их тойруугийн гудамж

7. Бага тойруугийн гудамж

8. Мандал худалдааны талбай

9. Номгон худалдааны талбай

10. Баруун лагерийн худалдааны талбай

11. Зүүн лагерийн худалдааны талбай

12. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газар-Нарлагын 1-ийн голоорхи зам

13. Мандалын-10-ын засмал зам

14. Зоогийн 1-ийн өмнөх засмал зам

15. Арвижих-Зоогийн голоор дээш явдаг зам

16. Арвижихын-5-ын өмнөх засмал зам

2. Сонгуулийн тухай хуулийн хүрээнд дээрхи нэр заагдсан гудамж, талбай, газарт сонгуулийн сурталчилгааны материалыг байршуулж, орчныг бохирдуулахгүй байдлыг хангаж ажиллахыг нэр дэвшигч нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэхийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Б.ӨЛЗИЙБАЯР